Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 2 дугаар хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 16-ны өдөр Дугаар ...01/2025 Улаангом хот

## Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын **Увс** аймгийн **Улаангом** сумын **3-р** багийн нутаг дэвсгэрт баригдсан **дунд төвөгшилтэй** ангиллын **үзвэр үйлчилгээний** зориулалттай **хөгжимт драмын "Ойрад" театрын** барилга угсралтын ажил **Увс** аймгийн Засаг даргын **2025** оны **01** сарын **10** -ны өдрийн **А/13** дугаар шийдвэрээр байгуулагдсан **21** хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс **2025** оны **01** сарын **16**-ны өдрөөс эхлэн **1** хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

## Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний **2019 он 11 сарын 20 өдөр, №БЗ-84/2019**;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: **ӨИ-03/2019**;

2.3. Захиалагч: **Аймгийн ЗДТГазар,** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар ......................., регистрийн дугаар ........................., Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 3-р баг, Ө.Бадрахын гудамж, Нутгийн удирдлагын ордоны байр, холбоо барих утас: **70453928,** И-мэйл хаяг:.............................................;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: **"Дүрт Уул" ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар **9011044006**, регистрийн дугаар **5083974**, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар **БУ17-34/17**, Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 15-р хороо, Москва 44-р байр, 73 тоот, холбоо барих утас: **99019450, 99049450**, И-мэйл хаяг: durtuul@gmail.com;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: -

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: **"Өлзий Иш" ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар ...................................., регистрийн дугаар **2890836**, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар **ЗТ18-1285/18**, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Мөнгөт шарга барилгын байр, 902 тоот, холбоо барих утас: **99186419**, И-мэйл хаяг: lho555@yahoo.com;

2.8. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Соёл, урлагын газар;

2.9. Барилга байгууламжийн төлөв байдал: **Ашиглалтын шаардлага хангасан**;

## Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү Монгол Улсын **Увс** аймгийн **Улаангом** сумын **3-р** багийн нутаг дэвсгэрт баригдсан **дунд төвөгшилтэй** ангиллын **үзвэр үйлчилгээний** зориулалттай **хөгжимт драмын "Ойрад" театрын** барилга угсралтын ажил, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж,

барилгын засварын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад **14** хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт … хуудас, хуралдааны тэмдэглэл … хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт … хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ..... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Энэхүү Монгол Улсын **Увс** аймгийн **Улаангом** сумын **3-р** багийн нутаг дэвсгэрт баригдсан **дунд төвөгшилтэй** ангиллын **үзвэр үйлчилгээний** зориулалттай **хөгжимт драмын "Ойрад" театрын** барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: С.Нямжав (ГХБХБГ-ын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Зоригт (ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Дүгэрсүрэн ("Дүрт Уул" ХХК-ны захирал)

Ч.Оюунчимэг ("Дүрт Уул" ХХК-ий инженер)

УЛААНБААТАР ХОТ ДҮРТ-УУЛ ХХК ТТА4065 5083874

Увс аймгийн Улаангом сумын 3-р багт шинээр баригдсан
хөгжимт драмын "Ойрад" театрын барилгын ажлыг ашиглалтад оруулах
комиссын хурлын тэмдэглэл

2025 оны 01-р сарын 16-ны өдөр Улаангом сум

Хурал: Ойрад Хөгжимт драмын театрын барилгын бага зааланд хуралдав.

Хуралд: С.Нямжав /Аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/
Б.Батболд /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/
Б.Зоригт /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн/
Б.Мөнхбаяр /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн/
Н.Тэсхүү /Аймгийн Архивын тасгийн дарга/
Р.Соёлмаа /Аймгийн ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /
Т.Оюунцэцэг /Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газар/
Б.Ганцог /Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГзахирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч/
Ц.Гантөмөр /Улаангом сумын Засаг дарга/
Ц.Бумбаяр /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч/
Х.Ганчимэг /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагч/
Л.Батбаяр /ОБГ-ын гал түймрийн УХ-ын байцаагч ахмад/
Ж.Жигжидсүрэн /ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч/
Б.Ганчимэг /ЭМГ-ын Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч/
Б.Балжинням /ЦТС ХХК-ийн инженер/
И.Нэргүй /ЦТС ХХК-ийн инженер/
З.Мятав /Аймгийн МХС ТӨК-ийн инженер/
Б.Мөнхзаяа /Чандмань Увс ХХК-ний инженер/
П.Бат-Орших /Улаангом Дулааны 2-р станц ТӨХК-ний ерөнхий инженер/
Ц.Чулуунбаатар /МХБИЧҮЭ-ийн холбооны Увс аймгийн зөвлөлийн тэргүүн/
Г.Батсүх /Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/
Б.Лхагвасүрэн /Иргэний төлөөлөл/
Б.Ичинхорлоо /Өлзий Иш ХХК-ний захирал/
Л.Гантулга /Өлзий Иш ХХК-ний инженер/
М.Уранбилэг /Өлзий Иш ХХК-ний инженер /
А.Солонго /Өлзий Иш ХХК-ний инженер /
Ч.Оюунчимэг /Дүрт Уул ХХК-ний гүйцэтгэх захирал, ерөнхий инженер/
Н.Баясгалан /Дүрт Уул ХХК-ний инженер/ нар оролцов.

Хэлэлцсэн асуудал: Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах тухай.

**Б.Зоригт: ГХБХБГ-ын БХБХ-ийн мэргэжилтэн**

Захирамжийн төслөө танилцуулий. Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн дугаар А/13 тоот комисс байгуулах захирамж гарсан, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь: Дүрт Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багийн Хөгжимт драмын "Ойрад" театрын барилгын угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Комиссын даргаар Аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Нямжав, Нарийн бичгийн даргаар Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Зоригт, Гишүүдэд Аймгийн Аймгийн ЗДТГ-ын архивын тасгийн дарга Н.Тэсхүү, Улаангом сумын Засаг дарга Ц.Гантөмөр, Аймгийн ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Соёлмаа, Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Б.Батболд, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Т.Оюунцэцэг, ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн Б.Мөнхбаяр, Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГ захирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч З.Балжинням, Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Л.Батбаяр, ГХБХБГ-ын Барилга техник хяналтын улсын байцаагч Ж.Жигжидсүрэн, АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Ц.Бумбаяр, АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Х.Ганчимэг, ЭМГ-ын эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Б.Ганчимэг, "ЦТС" ХХК-ий ерөнхий инженер В.Чинзориг, "МХС" ТӨК-ий дарга Я.Бат-Орших,

Увс аймгийн Улаангом сумын 3-р багт шинээр баригдсан хөгжимт драмын “Ойрад” театрын барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссын хурлын тэмдэглэл

2025 оны 01-р сарын 16-ны өдөр Улаангом сум

Хурал: Ойрад Хөгжимт драмын театрын барилгын бага зааланд хуралдав.

Хуралд: С.Нямжав /Аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/
Б.Батболд /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/
Б.Зоригт /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн/
Б.Мөнхбаяр /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн/
Н.Тэсхүү /Аймгийн Архивын тасгийн дарга/
Р.Соёлмаа /Аймгийн ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /
Т.Оюунцэцэг /Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газар/
Б.Ганцог /Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГзахирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч/
Ц.Гантөмөр /Улаангом сумын Засаг дарга/
Ц.Бумбаяр /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч/
Х.Ганчимэг /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагч/
Л.Батбаяр /ОБГ-ын гал түймрийн УХ-ын байцаагч ахмад/
Ж.Жигжидсүрэн /ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч/
Б.Ганчимэг /ЭМГ-ын Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч/
Б.Балжинням /ЦТС ХХК-ийн инженер/
И.Нэргүй /ЦТС ХХК-ийн инженер/
З.Мятав /Аймгийн МХС ТӨК-ийн инженер/
Б.Мөнхзаяа /Чандмань Увс ХХК-ний инженер/
П.Бат-Орших /Улаангом Дулааны 2-р станц ТӨХК-ний ерөнхий инженер/
Ц.Чулуунбаатар /МХБИЧҮЭ-ийн холбооны Увс аймгийн зөвлөлийн тэргүүн/
Г.Батсух /Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/
Б.Лхагвасүрэн /Иргэний төлөөлөл/
Б.Ичинхорлоо /Өлзий Иш ХХК-ний захирал/
Л.Гантулга /Өлзий Иш ХХК-ний инженер/
М.Уранбилэг /Өлзий Иш ХХК-ний инженер /
А.Солонго /Өлзий Иш ХХК-ний инженер /
Ч.Оюунчимэг /Дүрт Уул ХХК-ний гүйцэтгэх захирал, ерөнхий инженер/
Н.Баясгалан /Дүрт Уул ХХК-ний инженер/ нар оролцов.

Хэлэлцсэн асуудал: Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах тухай.

**Б.Зоригт: ГХБХБГ-ын БХБХ-ийн мэргэжилтэн**

Захирамжийн төслөө танилцуулий. Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн дугаар А/13 тоот комисс байгуулах захирамж гарсан, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь: Дүрт Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багийн Хөгжимт драмын “Ойрад” театрын барилгын угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Комиссын даргаар Аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Нямжав, Нарийн бичгийн даргаар Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Зоригт, Гишүүдэд Аймгийн Аймгийн ЗДТГ-ын архивын тасгийн дарга Н.Тэсхүү, Улаангом сумын Засаг дарга Ц.Гантөмөр, Аймгийн ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Соёлмаа, Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Б.Батболд, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Т.Оюунцэцэг, ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн Б.Мөнхбаяр, Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГ захирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч З.Балжинням, Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Л.Батбаяр, ГХБХБГ-ын Барилга техник хяналтын улсын байцаагч Ж.Жигжидсүрэн, АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Ц.Бумбаяр, АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Х.Ганчимэг, ЭМГ-ын эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Б.Ганчимэг, “ЦТС” ХХК-ий ерөнхий инженер В.Чинзориг, “МХС” ТӨК-ий дарга Я.Бат-Орших,

“Чандмань Увс” ХХК-ий ерөнхий инженер О.Батбаяр, Улаангом дулааны II станц ТӨХК-ий ерөнхий инженер П.Бат Орших, МХБИЧҮЭ-ийн Увс аймаг дахь ҮЭ-ийн зөвлөлийн тэргүүн Ц.Чулуунбаатар, Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батсүх, Иргэний төлөөлөл Б.Лхагвасүрэн, Зураг төслийн “Өлзий Иш” ХХК-ийн захирал Б.Ичинхорлоо, “Дүрт Уул” ХХК-ий барилгын инженер Ч.Оюунчимэг, нарын бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж байна. 2. Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлыг хууль, дүрмийн дагуу хүлээн авч ажиллахыг улсын комисс /С.Нямжав/-д даалгасугай. Засаг дарга С.Батжаргал гэсэн байна. Улаангом сумын засаг дарга Ц.Гантөмөрийг орлон Улаангом сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Г.Мөнхгэрэл, “ЦТС” ХХК-ий ерөнхий инженер В.Чинзоригийг орлон инженер И.Нэргүй, Б.Балжинням, ОБГ-ын гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Л.Батбаярыг орлон гал түймрийн улсын хяналтын байцаагч ахлах дэслэгч Б.Мөнхтулга, Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГ захирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч З.Балжиннямыг орлон Улаангом сум тохижилт үйлчилгээ ОНТҮГ мэргэжилтэн Б.Ганцог, МХС ТӨК-ын дарга Я.Бат-Оршихыг орлон “МХС” ТӨК-ий инженер З.Мятав, “Чандмань Увс” ХХК-ий ерөнхий инженер О.Батбаярыг орлон “Чандмань Увс” ХХК-ий инженер Б.Мөнхзаяа нар оролцож байна. Барилгатай танилцсан тул хурлаа үргэлжлүүлэе.

**Б.Зоригт: ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцаж явж үзлээ. Та бүгд асууж тодруулах зүйл байвал асууж тодруулна уу. Гишүүдэд гүйцэтгэгч байгууллагаас асууж тодруулах зүйл байна уу?

**С.Нямжав: ГХБХБГ-ын дарга**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцаж явж үзлээ. Ингээд комиссын хурал эхэлж байна. Хурал эхэлсэнтэй холбогдуулаад комисс ажиллах уу ажиллахгүй гэдэгт гишүүд гараа өргөж шийдий. Бүгд комисс ажиллахаар зөвшөөрч бүгд өргөсөн тул комисс ажиллахыг мэдэгдэе. Та бүгд асууж тодруулах зүйл байвал асууж тодруулна уу. Гишүүдэд гүйцэтгэгч байгууллагаас асууж тодруулах зүйл байна уу?

**Ж.Жигжидсүрэн / ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Асууж тодруулах зүйл байна. Барилгын металл ферм, хөшиг, гэрэлтүүлгийн туслах фермд гүйцэтгэлийн зураг тооцоолол хийлгэсэн үү, металл фермийг тасдаж холболтууд хийгдсэн хүчдэлийн зураг төсөл байгаа юу түүний дагуу хийж гүйцэтгэсэн үү. Зургийн байгууллага хариулан уу.

**А.Ичинхорлоо: “Өлзий Иш” ХХК-ий захирал**

Барилгын металл ферм, хөшиг, гэрэлтүүлгийн туслах фермд гүйцэтгэлийн зургийн дагуу хийж гүйцэтгэсэн. Ферм тасдаж нэмэлт холболтыг хийж гүйцэтгэсэнд даацын тооцоо хийж түүний дагуу гүйцэтгэлийн зураг хийсэн. Тооцоогоор одоо байгаа металл фермийн даац хангагдаж байгаа болно. Түүний дагуу гүйцэтгэгч байгууллага хийж гүйцэтгэсэн.

**Ч.Оюунчимэг /Дүрт Уул ХХК-ний гүйцэтгэх захирал, ерөнхий инженер/**

Манай компани нь Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлыг 15,373,527,749 төгрөгөөр гүйцэтгэхээр тендерт шалгаран 2019 оны 09-р сарын 27-ий өдөр Аймгийн Засаг даргатай БСШУСЯ/201902282 тоот гэрээ байгуулж, 2019 оны 10-р сард ажил эхэлсэн.

Зураг төсөв хийгдэж магадлалаар батлагдсан нийт төсөвт өртөг нь 15,373,527,749 төгрөг болсон болно.

Тэнхлэгээрээ 52.2 м x 82.7 м хэмжээтэй, 0 түвшнээс доош 1 давхар зоорьтой, 0 түвшнээс дээш 3 давхар, тайзны хэсэг 24 метр өндөр, 4 блок барилгаас бүрдсэн барилга байна.

Барилга угсралтын ажлыг дээд талдаа 100 хүний бүрэлдэхүүнтэй бригад, барилгын норм дүрэм стандарт журмыг баримтлан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн.

**Зураг төсөл**: Увс аймгийн Ерөнхий архитекторын 2019.02.22-ны өдөр баталсан 06/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, Увс аймгийн Засаг даргын 2019.04.11-ний өдөр баталсан ЗТ-15/2019 дугаартай зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу зураг төслийн "Өлзий –Иш" ХХК боловсруулж 2019.11.13-ны 1945/2019 дугаартай магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр баталгаажсан.

**Гэрээ байгуулсан огноо**:

1. 2019.09.27-ны өдөр барилга угсралтын ажлыг 6,8 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэх гэрээг байгуулсан.

2. Театрын гадна тохижилт, зам талбай, интерьер, технологийн хэсгийн зураг төсөл нь 2021.07.23-ны өдрийн 1039/2021 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажсан бөгөөд 2022.08.12-ны өдөр гадна тохижилт, зам талбай, интерьер, технологийн ажил гүйцэтгэх 3,726 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан.

3. Мөн УИХ-ын 88 дугаар тогтоолын хүрээнд материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцсон бөгөөд 287 сая төгрөгийн үнийн дүн бүхий материалын өсөлтийг экспертээр хянуулан баталгаажуулж 2024 онд олгогдсон.

4. Нэмэлтээр хийгдэх, төсөвт тусгагдаагүй ажлуудын зураг төсөл 2023.09.29-ний өдрийн 1540/2023 дугаартай магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр баталгаажсан. Гэрээг Увс аймгийн Засаг даргатай 2024.03.06-ны өдөр 4,559 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан.

Гадна тохижилтийн хувьд байгууллагын гадна хашаа, усан хана, усан оргилуур, явган зам, ногоон байгууламж, гадна задгай тоглолтын тайз, гадна машины зогсоол төлөвлөгдөн баригдсан.

Дотор тайз 12*6 м лед дэлгэцтэй, 686 хүний суудалтай, хөгжимчдийг өргөх, хоорын дуучдыг өргөх хөдөлгөөнт автомат тавцан 6 ширхэг, автомат хөшиг, аудио дууны систем 10 ширхэг өсгөчийг удирдлагын пультийн хамт, гэрэлтүүлгийн систем, 8500 мм диаметртэй эргэдэг тайз нь хурдны олон янзын шатлалтай байх бөгөөд зураг төсөлд заасны дагуу автомат, компьютерт холбогдсон сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий Монгол улсад шинэ технологийн дагуу хийж гүйцэтгэсэн. Мөн хурлын зааланд 6*3 м-ийн 2 ширхэг дэлгэц, 200 зөөврийн сандлыг байрлуулсан. Бэлтгэлийн заал, үзвэрийн заалны ханыг дуу тусгаарлагч эсгий хавтангаар хийж дотор заслыг зураг төсөлд заасны дагуу хийж гүйцэтгэсэн.

Барилгын ажил явагдаж байх хугацаанд Төрийн Аудитын байгууллагаас 2 удаагийн шалгалт орж ямар нэгэн зөрчил илрээгүй болно.Суурийн ажлыг эхлэхийн өмнө мэргэжлийн геодезийн "Аэрогеодез"ХХК-ны инженерүүд улаан шугам тавьж баталгаажуулсан.

Соёлын яамны хяналтын инженер, ГХБХБГ-ын дарга, хяналтын инженерүүд, зураг төсвийн байгууллагын хяналтын инженер болон чиглэл чиглэлийн хариуцсан мэргэжилтэн албан тушаалтануудтай байнгын холбоотой харилцан уялдаатай ажиллаж ирсэн.

Ажил гүйцэтгэх явцад ашиглагч байгууллагыг байлцуулан тоног төхөөрөмжийн угсралт болон ажиллагааны талаар байнга заавар зөвлөмж өгч ажилласан.

Манай компани нь энэхүү барилгын угсралтын явцад ХАБЭА-н дүрэм журмыг ажиллагсддад сайтар мөрдүүлсний үр дүнд нэг ч аваар осолгүй ажилласан.

Зураг төслийн дагуу ажил дуусч, туршилт тохиуулга хийгдэж байгаа тул улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтанд хүлээн авахыг хүсч байна.

**А.Ичинхорлоо: "Өлзий Иш" ХХК-ий захирал**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Хөгжимт драмын Ойрад театрын барилгын угсралтын ажил дуусч өнөөдөр улсын комисс ажиллаж байна. Энэ барилгын хувьд 2019 онд хийж гүйцэтгэх санал ирүүлсэнээр ажлаа хийж эхэлсэн. Богино хугацаанд хийж дуусгахад хэцүү байсан. Улсын төсөвт 7,6 тэрбум төгрөг суусан байсан болович ашиглагч, захиалагч нарын саналын дагуу хийхэд хаана ч хүрэлцэхгүй мөнгө байсан. Төсөвт өртөгт нь барилгын ажил жүү чамаа багтаж байсан. Нэмэлтээр хийгдэх дотор интерьер дизайны ажил, гадна тохижилтын ажил, нэмэлт ажлууд багтахгүй байсаныг дахин улсын төсөвт суулгасанаар түүний дагуу зураг төсөв хийж магадлалаар баталгаажуулж ажлаа гүйцэтгэсэн байна. Энэ барилга монгол улсад ганцхан барилга юмаа. 2024 оны 12 сарын 28-ны өдрийн №08/24 дугаартай Барилга угсралтын ажлын талаарх зохиогчийн нэгдсэн дүгнэлтээ уншиж танилцуулъя. Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан

Хөгжимт драмын Ойрад театрын барилга нь зоорьтой, 3 давхар, арагт бүтээцэт хийцтэй, тэнхлэгээрээ 52,2 x 82,7 метрийн хэмжээтэй болно. Захиалагч байгууллага нь Соёлын яам, Аймгийн ЗДТГазар юм. Барилгын ажил 2019 оны 09 сард эхэлж, 2024 оны 12 сарын 18-ны өдөр дууссан. Ерөнхий зүйл: Увс аймгийн Хөгжимт драмын Ойрад театрын барилга нь ӨИ-03-19 шифртэй зураг, төсвийг 2019 онд боловсруулж, БХТ-тэй байгуулсан Е-0466/2020 тоот зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын гэрээний дагуу экспертиз хийлгэн 2019 оны 11сарын 13-ны №1945/2019 тоот ерөнхий дүгнэлт гаргуулсан. Хөгжимт драмын Ойрад театрын барилгын гадна тохижилт, зам талбай, интерьерийн ажлын зураг төсвийг 2021 онд боловсруулж 2021 оны 07 сарын 28-ны №1039/2021 тоот ерөнхий дүгнэлт гаргуулсан. Барилга баригдах газар нь Увс аймгийн Засаг даргын 2013 оны 05 сарын 06-ны өдрийн А/286 тоот захирамжийн дагуу олгогдсон. Ажлын зураг төсөл Онцгой байдлын ерөнхий газар, Увс аймгийн ЗДТГазар, ГХБХБГ, МХГазраар батлагдаж зохих бичиг баримт, зөвшөөрлүүд авагдсан. Манай компани нь захиалагч Увс аймгийн Улаангом сумын Засаг даргатай 2019 оны 04 сарын 03-ны өдөр байгуулсан ЗТ-09/19 тоот, 2020 оны 09 сарын 15-ны өдөр байгуулсан ЗТ-13/20, ЗТ-18/20 тоот зураг төслийн ажлын гэрээ, ГХБХБГазартай 2019 оны 11 сарын 29-ны өдрийн №07/2019, 2022 оны 08 сарын 18-ны өдрийн №02/2022, 2024 оны 04 сарын 09-ны өдрийн№10/24 тоот Барилга угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээнүүдийг байгуулж барилга архитектур, барилга бүтээц, халаалт салхивч, цэвэр бохир ус, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиолол, гадна шугам сүлжээний зургуудыг боловсруулан зохих хяналтыг хийж гүйцэтгэлээ. Зураг төсөл, техникийн баримт бичгүүд иж бүрдсэн. Барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт хийх үед захиалагч Соёлын яамны СХОГ-ын хяналтын инженер Д.Одгэрэл, ГХБХБГазрын хэлтсийн дарга Б.Батболд, мэргэжилтэн Б.Зоригт, гүйцэтгэгч “Дүрт Уул” ХХК-ий ерөнхий инженер Ч.Оюунчимэг, талбайн инженер , Н.Баясгалан болон зохиогчийн инженер А.Ичинхорлоо, Д.Ганчимэг, инженер Л.Гантулга, М.Уранбилэг, А.Солонго нар оролцсон Зохиогчийн хяналтын инженерүүд барилгын суурь, арагт бүтээц, өрлөг, дээвэр, цахилгаан холбоо, сантехник, гадна дотор засал, шугам сүлжээ зэрэг үндсэн ажлуудад хяналт тавин заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Барилга архитектур: Увс аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр баталсан №ЗТ-15/2019 тоот Аймгийн хөгжимт драмын Ойрад театрын барилгын зураг төсөв боловсруулах даалгавар, Увс аймгийн ерөнхий архитектурын 2019 оны 02 сарын 22-ны өдөр баталсан №06/2019 тоот архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу ажлын зураг боловсруулсан. Барилга бүтээц: барилгын үндсэн хийцүүдийн угсралтыг батлагдсан зураг төслийн дагуу хийсэн. Үүнд барилгын суурь, арагт бүтээц, хучилтын арматурчлал, бетоны цутгалт, гадна дотор ханаы өрлөг, дээвэр зэрэг ажлууд болно. Эргэдэг тайзны бетон суурь хийсэнтэй холбогдуулан тайзны хэсгийн хучилтад нэмэлт бэхэлгээ хийсэн. Барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэсэн тухай тайлангуудыг аймгийн ГХБХБГазарт гарган өгсөн. Барилгын дотор шугам сүлжээ: халаалт агаар сэлгэлтийн угсралт зураг төслийн дагуу хийгдсэн, тоног төхөөрөмжийн марк зургаас өөрчлөгдсөн. Цэвэр бохир усны системийн угсралт зургийн дагуу хийгдсэн. Цэвэр усан хангамж шинээр баригдсан ЦТП-ээс холбогдсон тул галын усны нөөцийн савны хэмжээг 40м3 болгон өөрчилсөн. Дотор цахилгаан хангамж, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлгийн угсралтыг зураг төслийн дагуу хийсэн. Дотор холбоо дохиоллын угсралтыг батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн. барилгын гадна шугам сүлжээ, гадна дулаан, шинээр ЦТП баригдсантай холбоотойгоор гадна дулааны худаг №02 хийсэн. Гүйцэтгэлийн зураг хийж баталгаажуулах. Усан хангамж ариутгах татуурга, гадна ариутгах татуургын техникийн нөхцөл шинэчлэгдэж трасс өөрчлөгдсөн. Гүйцэтгэлийн зураг гаргаж баталгаажуулах. Гадна цахилгаан хангамж зургийн дагуу хийгдсэн. Гадна холбоо зургийн дагуу хийгдсэн. Барилгын гүйцэтгэгч тал ажлын явцын талаар барилгын талбайн тэмдэглэлийг хөтөлж, ил далд ажлын актыг бүрдүүлжээ. Манай байгууллагаас уг барилгыг ашиглалтад оруулахын өмнө гүйцэтгэгчид барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах дүрэмд заасны дагуу шаардлагатай бичиг, техникийн зураг, баримтууд бүрдүүлэх талаар зааварчилгаа өгч, техникийн үзлэг хийв. Урьдчилсан үзлэгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгасан Дүгнэсэн нь: Увс аймгийн Улаангом сумын хөгжимт драмын Ойрад театрын барилгын угсралтын ажлыг гүйцэтгэгч “Дүрт Уул” ХХК нь гүйцэтгэж дууссан байна. Барилгыг Улсын комиссоор оруулж байнгын ашиглалтад хүлээн авна. Дүгнэлт гаргасан Өлзий Иш ХХК-ий захирал, инженер А.Ичинхорлоо, инженер Л.Гантулга, А.Солонго, М.Уранбилэг нар болно.

**Б.Зоригт: ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн**

Барилгын ажлын явцад захиалагчийн техникийн хяналтыг хийж ажилласан. Гэрээний дагуу томилогдон ажиллаж байна. Барилгын холбогдох дүрэм, журам, БНбД-ын дагуу захиалагчийн хяналт тавьж ажилласан. Хяналтыг барилга угсралтын явцад тогтмол хийж ажиллаж байсан. Хяналтыг хийж гүйцэтгэх явцдаа Соёлын яамны хяналтын инженер, аймгийн холбогдох байгууллага, зургийн байгууллагын хяналтын инженер, ашиглагч байгууллагатай

хамтарсан хяналтыг хийж ажиллаж байсан. Барилгын төмөр бетон арагт бүтээц хийц дээр хээрийн лабораторийн Ре констракшн ХХК-ий инженер профессор Дүйнхэржав ирж шалгалт, хяналт хийсэн. Шалгалтаар сайн үнэлэгдсэн байна. Уг барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэгч байгууллага зураг төслийн дагуу бүрэн хийж дуусгасан. Байнгын ашиглалтанд ороход бэлэн болсон.

**П.Бат Орших /УДС-2 ТӨХК-ний ерөнхий инженер/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Хөгжимт драмын Ойрад театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Гадна худагт байрлах шугам хоолойг дулаалга ороож цэвэрлэх
2. Гүйцэтгэлийн зургийг хүлээлгэн өгөх.
3. ХХУ-ны буцах шугамд тоолуур тавих.
4. Манометр баталгаажуулах.
5. Узелийн перемичек устгах, хаягжуулах.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Б.Мөнхзаяа / Чандмань Увс ХХК-ний инженер/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг
2. Гадна бохир усны шугамыг газрын түвшиндтэнцүүлэн цэвэрлэн дулаалах
3. Гадна цэвэр усны шугамыг цэвэрлэж дулаалах
4. Узелийн шугамыг цэвэрлэж шаардлагатай бол нэмэлтээр ф50 тоолуур тавих

Уг барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**З.Мятав /МХС ТӨК-ний инженер/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Холбооны эхний худаг эвдэрсэн хэсгийг бүтэн болгох.
2. 1 ширхэг худгийн таг хүзүү хийж суурилуулах.
3. Автомашины зогсоол дээрх худгийг газрын түвшинтэй тэгшлэх.
4. Холбооны сувагчлал барилга руу орох хэсгийг ил гаргаж кабель татахад саадгүй болгох.
5. Худгуудад тавиур хийх.
6. Холбооны гадна шугамын гүйцэтгэлийн зураг хийлгэж өгөх.

Дотор монтажыг технологийн дагуу хийсэн. Улсын комиссоор хүлээж авахад татгалзах зүйлгүй.

**Б.Балжинням /Увс ЦТС ХХК-ний инженер/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Ерөнхий щитний 5А-н тоолуурыг ухаалаг тоолуураар солих
2. Группын самбар щитний хаягжилт хийх
3. Группын самбарын цахилгааны холболт дээр төгсгөвч шахаж холболт хийх
4. Тайзны хөшигний удирдлагын тавцан самбарт гэрэлтүүлэг хийх
5. Дизель генератор хэвийн ажиллагаанд оруулах
6. Тоолуурын заалтаар төлбөр тооцоо хийх.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**И.Нэргүй /Увс ЦТС ХХК-ний инженер/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал: Увс ЦТС ХХК-ний инженер Б.Балжиннямтай санал нэг байна. Барилга угсралтын ажлыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Комиссын гишүүн: Б.Ганцог /Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ мэргэжилтэн/

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Ногоон байгууламжийн дутуу ажлыг дулааны улиралд бүрэн хийж гүйцэтгэх.
2. Магадлашгүй ажлын төсвөөр боломжтой бол хог хаягдал хадгалах цэг байгуулах. /ашиглагч байгууллагатай зөвшилцөх./

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**Ц.Чулуунбаатар /МХБИЧҮЭ-ийн хлбооны Увс аймгийн зөвлөлийн тэргүүн/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. ХБИ-н налуу замын пандусын гялгар хавтан солих
2. Налуу замын эхлэл дээр самбар хийх
3. ХБИ-ий автомашины зогсоолоос явган хүний замд налуу хийх
4. ХБИ-ий ариун цэврийн өрөөнд татуурга хийх
5. Явган хүний замын голоор хөтөч хавтан хийх
6. ХБИ-ий Автомашины зогсоолыг стандартаар хийх

Уг барилга байгууламжтай танилцлаа. Стандартын шаардлага хангасан барилга барьсан байна. Өвлийн хүйтэн гадна ажлыг хийх боломжгүй байгаа тул хавар дулаарахаар зогсоолын тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэж өгөх. Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Ц.Бумбаяр /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн ЭХХУБайцаагч/**

1. Хурлын заалны цонх, зүүн жигүүрийн шатны хажуугийн босоо цонхны сийгэлт засах
2. Зүүн жигүүрт радиоторын бэхэлгээ хийх
3. Цахилгааны самбарын газардуулга гүйцээж хийх
4. Цахилгааны самбар,дулааны коллектрын хайрцганд цэвэрлэгээ хийх
5. ГС-17 самбарын пускатель солих
6. Ашиглагч байгууллагад дулаан, цахилгааны тарифыг барагдуулах
7. Ариун цэврийн өрөөнд тэмдэглэгээ хийх
8. Гүйцэтгэлийн зураг
9. Техникийн нөхцөл шинэчлэх
10. Гагнуурын ажлын акт үйлдэх

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**Х.Ганчимэг /АЗДТГ-ын ХБТХОХ-ийн Мэдээлэл Харилцаа холбооны улсын байцаагч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Ил далд ажлыг бичиж гүйцээж баталгаажуулах.
2. Тоног төхөөрөмжийн хаягжуулалт хийх.
3. Худгийн таг хүзүү хийж битүүмжлэх.
4. Зогсоолын худаг сувагчлалын стандартын дагуу газрын түвшинд суурилуулах.
5. Галын щитын холболтыг шалгаж ажиллагаанд оруулах.
6. Кабелийн тавиур суурилуулах худагт.
7. Гүйцэтгэлийн зураг хийлгэж МХС ТӨК-д хүлээлгэн өгөх.
8. Сувагчлалын хоолойг ил гаргах.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Г.Мөнхгэрэл /Улаангом сумын ЗДТГ-ын мэргэжилтэн/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Гадна ногоон байгууламжийг дулааны улиралд хийж гүйцэтгэх, гэрээг хот тохижуулалттай байгуулах.
2. Үндсэн заалны дэлгэц үзэгдэх орчин захын суудалд муу харагдаж байна.
3. Цэвэрлэгээ хийх.
4. Дулаан алдагдал арилгах.

Тавьсан үүрэг даалгавар биелэлтээр байнгын ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

**Н.Тэсхүү /АЗДТГ-ын Архивын тасгийн дарга/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Зураг төсөвт орсон өөрчлөлтийг баримтаар хавсаргах.
2. Баримт бичгийн бүрдэл стандартад нийцүүлж архивт эх хувь баримтаар хүлээлгэн өгөх.
3. Ил далд ажлын актын гарын үсгийн бүрдэл хангах.
4. Улаан шугам тэг тэнхлэг тавьсан акт гарын үсэг дутуу байна гүйцээх.
5. Ажлын явцын фото зураг хангалтгүй байна.
6. Дүрт Уул ХХК-иас гаргаж байгаа албан тушаалтны томилсон шийдвэр тушаалууд албан ёсны хэвлэмэл хуудас дээр гаргах.
7. Зохиогчийн нэгдсэн дүгнэлтээ хавсаргах, бусад бичиг баримтын хамтаар архивт өгөх.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**Ж.Жигжидсүрэн / ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Халаалтын уян хоолойн холбоосуудад хамгаалалт хийх
2. Хар цаасны ам дарж хар тосоор наах
3. Барилгын металл ферм, хөшиг, гэрэлтүүлгийн туслах фермд гүйцэтгэлийн зураг тооцоолол хийлгэсэнд зохиогчоор дүгнэлт гаргуулах,
4. металл фермийн хүчдэлийн зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.
5. Фасадны чигжээсүүдийг гүйцээж хийх.
6. Барилгын орц гарцад нэмэлтээр халуун хөшиг хийж өгөх.

Байнгын ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

**Б.Мөнхтулга /ОБГ-ын Гал түймрийн улсын байцаагч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Цахилгааны щитүүдэд таних тэмдэглэгээ хийх.
2. Утаа мэдрэгчүүдийн тагуудыг авах
3. Зургийн компанитай хамтран аваар ослын үеийн аврах зам гарцын схем зураг боловсруулж давхар бүрт байрлуулах
4. Гадна дулаалгын материалын шинжилгээний дүгнэлт
5. Барилга байгууламжинд зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах
6. Гарц заасан тэмдэг тэмдэглэгээг гарцын чиглэл зааж коридорын эргэлт бүрт байрлуулах

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**Б.Мөнхбаяр: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. 3 давхрын паар бэхлэх, хоолойг далдлах
2. Дээврийн хар цаасны ам дарах
3. Дулааны улиралд хийх ногоон байгууламжийн ажлын гэрээ хийх

4. Тайзны гэрэлтүүлэг,хөшиг бэхэлсэн төмрийн тайрсан хэсэгт нэмж бэхэлгээ нөхөж хийх

Барилгын комисст ажиллаа. Барилга нь зураг төсвийн дагуу сайн баригдсан байна. Барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**А.Ичинхорлоо: "Өлзий Иш" ХХК-ий захирал**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Тайзны технологитой холбоотой нэмэлтээр хийсэн тайзны дээд хөндийд байрлах металл холбоос татангийг гүйцэтгэлийн ажлын зураг гаргах.
2. Тайрсан байгаа босоо ташуу холбоосыг сольж шинээр хийх.
3. Ханаы анкерыг цавуун бэхэлгээтэй боолт хийх.
4. Төв замаас авто зогсоол руу орох налуу хэсэгт ус зайлуулах суваг хийх.
5. Гадна тохижилтын зүлэгжүүлэлтийг хийж гүйцэтгэх.
6. Шилэн фасад, металл фасадны уулзварын чигжээсийг сайтар хийх.

Барилгын комисст ажиллаа. Барилга нь зураг төсвийн дагуу сайн баригдсан байна. Барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Л.Гантулга: "Өлзий Иш" ХХК-ий инженер**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал: Барилгын комисст ажиллаа. Барилгын цахилгааны ажил нь зураг төсвийн дагуу сайн гүйцэтгэсэн. цахилгааны ажил явагдаж байх хугацаанд гүйцэтгэгч компани бидэнтэй хамтарч ажиллаж байсан. Барилгын материал сонголтон дээр бидэнтэй зөвшилцөж ажиллаж байсан. Барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**М.Уранбилэг: "Өлзий Иш" ХХК-ий инженер**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал: Барилгын комисст ажиллаа. Барилгын бүтээцийн ажил нь зураг төсвийн дагуу сайн гүйцэтгэсэн. барилгын ажил явагдаж байх хугацаанд гүйцэтгэгч компани бидэнтэй хамтарч ажиллаж байсан. Төмөр бетон карказны ажлыг сайн хийж гүйцэтгэсэн, өрлөгийн ажил, дотор заслын ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгэсэн. Ажлын явцын дунд хяналтыг хийж ажиллаж байсан. Барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**А.Солонго: "Өлзий Иш" ХХК-ий инженер**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал: Барилгын комисст ажиллаа. Барилгын халаалт, агаар сэлгэлтийн ажил нь зураг төсвийн дагуу сайн гүйцэтгэсэн. Барилгын ажил явагдаж байх хугацаанд гүйцэтгэгч компани бидэнтэй хамтарч ажиллаж байсан. Халаалт болон агаар сэлгэлтийг зургийн дагуу хийж гүйцэтгэсэн. Өөрчлөлтийн ажил байхгүй байна. Агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн өрөөг дуу тусгаарлах, галд тэсвэртэй материалаар доторлож өгөх. Ажлын явцын дунд хяналтыг хийж ажиллаж байсан. Барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Р.Соёлмаа / Аймгийн ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. 3 гэрээний төсөвт өртгийн дүнгээр хийсэн төсвийн задаргааг ОНӨГ-т өгөх
2. Зоорийн давхрын цэвэрлэгээ хийх
3. 00-өрөөний заримаас бохир үнэртэж байгааг янзлах
4. 2 давхарт нэг өрөөний хана ус алдаж өнгө үзэмж алдсныг засах
5. 2 давхрын паарыг бэхлэх
6. Техникийн паспорт хэрэглээний зааврыг ОЙРАД ХДТеатр-т өгөх холбогдох хүмүүст сургалт зааварчилгаа өгөх
7. Ашиглагч байгууллагад холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх мөн хөрөнгийг хүлээлгэн өгөх

Комиссын гишүүдээс гарсан санал үүрэг даалгаварыг хэрэгжүүлээд биелүүлэх, барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Т.Оюунцэцэг /Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газар/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал: Комиссын гишүүдтэй санал нэг байна. Комиссын гишүүдээс гарсан санал үүрэг даалгаварыг хэрэгжүүлээд биелүүлэх, барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Б.Ганчимэг /ЭМГазрын эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Ундны усыг шинжилгээнд хамруулж улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах.
2. Ногоон байгууламжийн ажлыг дулааны улиралд хийж дуусгах.
3. Дотоод орчны цэвэрлэгээг гүйцээж хийх.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**Б.Батболд /ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Гүйцэтгэлийн зураг ГХБХБГ-т хүлээлгэн өгөх
2. Ногоон байгууламжийн ажилд гурвалсан гэрээ байгуулан дулаарахаар хийж гүйцэтгэх.

Уг барилга байгууламжтай танилцлаа. Стандартын шаардлага хангасан барилга барьсан байна. Ер нь комиссын гишүүд бас зөвөөр ойлгох хэрэгтэй. Энэ компани ковидын цар тахалын үед барилгын ажлыг зогсоохгүйгээр бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажилласанд бас талархмаар байнаа. Өвлийн хүйтэн гадна ажлыг хийх боломжгүй байгаа тул хавар дулаарахаар зогсоолын тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэж өгөх. Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Г.Батсүх /Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Манай байгууллагын ажилчдын нэрийн өмнөөс энэ компаний хамт олонд баяр хүргэмээр байна. Ингээд саналаа хэлье.Хуралд оруулах санал:

1. Дутуу ажлуудыг гүйцээх.
2. Цэвэрлэгээг чанартай хийлгэх.
3. Цэвэр ус,халаалт,цахилгааны төлбөрөө хийж дуусгах.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Б.Лхагвасүрэн /Олон нийтийн төлөөлөл/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Намайг дарга хийж байх хугацаанд Зургийн байгууллага шалгараад ирж санал хүсэлт авч байсан. Бид нар хуралдаж том тайзтай заал, хурлын заал, фестивель, ажилчдын байр, бэлтгэлийн танхим, арын туслах ажилчдын байр гэх мэт саналаа өгсөн. Түүний дагуу зураг төсөв хийж гүйцэтгэгч байгууллага хийж гүйцэтгэсэн байна. Өнөөдөр би иргэний төлөөллийн хувьд оролцож байна. Үнэхээр сайхан барилга болсон байна. Хуралд оруулах санал:

1. Зрителийн тайзыг 12х6 метр хэмжээтэй лед дэлгэцийн гүйдэг зам дагуух цахилгааны утсыг аюулгүй болгож дээш өргөх боломжийг судлах.
2. Зоорийн давхрын шалыг өнгөлөх, будах.
3. Төв хаалганы гаднаас орж ирэх хэсэг, фестивелийн гэрэлтүүлгийн дизайн хүчин чадлыг нэмэгдүүлэх.

4. Гадна талбайн авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээг стандартад нийцүүлэн байрлуулах.
5. Хөгжмийн яам болон хоор дуучдын өргөх хэсгийг барилгын ажлын явцад үүссэн хог хаягдлыг цэвэрлэж аюулгүй байдлыг хангах.
6. Захиалагч байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг ажиллуулах техникийн ажилтнуудыг бэлтгэж өгөх.
7. Халаалт дулааны тоолууртай болгож ашиглалтын төлбөрөө төлж барагдуулах.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

**С.Нямжав / ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/**

Дүрт-Уул ХХК-ий гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажилтай танилцлаа. Хуралд оруулах санал:

1. Гадна тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэх
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний автозогсоол хийх
3. Тайзны фермийн холбоосыг нэмж хийх
4. Дотор тохижилтын дутуу чигжээсүүдийг хийж өгөх
5. Тайз, хөшиг, тоног төхөөрөмж зэрэг БНХАУ-ын гүйцэтгүүлсэн ажлын гэрээ, баталгааны дүгнэлтийг баталгаат орчуулгын газраар орчуулга хийж өгөх.

Барилга угсралтын ажлыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Ч.Оюунчимэг / "Дүрт-Уул" ХХК-ний ерөнхий инженер/**

Та бүхэнд баярлалаа. Манай компани нь Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлыг зургийн дагуу барилгын норм ба дүрмийн стандарт, технологийн дагуу барьж гүйцэтгэлээ. Миний бие "Дүрт-Уул" ХХК-ий захирал Ч.Дүгэрсүрэнг төлөөлөн ажиллаж байна. Коммисийн гишүүдээс өгөгдөж байгаа үүрэг даалгаврыг хүлээн зөвшөөрч байна. Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварт ажлуудыг 14 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Гадна тохижилтын ажлыг хавар дулаарахаар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх болно. "Ойрад" ХДТеатрын барилга угсралтын ажил болон тоног төхөөрөмжийн ажил дуусаж туршилтаар баталгаажсан.Шаардлагатай дүгнэлтүүд,бичиг баримтийн бүрдэл,ил далд ажлын актууд баталгаажин бэлэн болсон.Драмын барилга нь халаалт,салхивчийн систем,цэвэр усны хангамж,бохир усны систем нь хэвийн ажиллаж тохируулга хийгдэн хэвийн ажиллагаатай болсон. гадна шугам сүлжээ,гадна тохижилт,фасадны ажил,дотор заслын ажил бүрэн дууссан тул улсын комиссоор байнгын ашиглалтанд оруулахад татгалзах зүйлгүй.

**Э.Баясгалан: "Дүрт-Уул" ХХК-ий инженер**

Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Барилга угсралтын ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгээд одоо хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Байнгын ашиглалтад өгөхөд татгалзах зүйлгүй.

**Б.Зоригт: ГХБХБГ-ын БХБХ-ийн ахлах мэргэжилтэн**

Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлын Комиссын гишүүдийн гаргасан саналыг нэгтгэлээ. Гишүүдийн гаргасан саналыг гүйцэтгэгч компани хийхэд зөвшөөрч байгаа тул Хурлын гишүүдийн саналыг үндэслэж хурлын шийдвэрээ гаргая. Барилга угсралтын ажлыг улсын комиссоор үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

**Комиссын гишүүн: С.Нямжав / ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/**

Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлын Комиссын гишүүдийн гаргасан саналыг нэгтгэлээ. Гишүүдийн гаргасан саналыг гүйцэтгэгч компани хийхэд зөвшөөрч байгаа тул Хурлын гишүүдийн саналыг үндэслэж хурлын шийдвэрээ гаргая.

Барилга байгууламжийг ашиглалтанд авах дүрэм дээр заасны дагуу 1 гишүүн татгалзвал барилга байгууламжийг ашиглалтанд авахаас татгалзах үндэслэл болно гэсэн заасан байгаа.

Комиссын гишүүдийн гаргасан саналыг нэгтгэлээ. Бүгд үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтанд өгөх саналтай байна. Хурал дууссантай холбогдуулаад улсын комиссоор ашиглалтанд авахад комиссын гишүүдийн саналыг хийж гүйцэтгэх. Бичиг баримтыг бүрэн бүрдүүлэн хүлээлгэн өгөх, гүйцэтгэгч компани гишүүдийн өгсөн үүрэг даалгаварт ажлуудаа хийхэд зөвшөөрч байгаа тул улсын комисс хүлээж авахыг дэмжиж байна.

Энэ ажилуудыг хийж гүйцэтгэн хийгдсэний дараа биелэлтээ шалгуулж хянуулан албан тоотоор хандаж ирүүлэх.

Хурлын гишүүдийн саналыг үндэслэж хурлын шийдвэрээ гаргая.

**Шийдвэрлэсэн нь:**

**"Дүрт Уул" ХХК-ийн гүйцэтгэсэн Увс аймгийн Улаангом сумын 3-р багт баригдсан Ойрад Хөгжимт драмын театрын барилгын угсралтын ажлыг улсын комиссын гишүүдийн 100 хувийн саналаар үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад оруулав. Гүйцэтгэгч компани дараах үүрэг даалгавруудыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх. Үүнд:**

1. Баримт бичгийн бүрдэл стандартад нийцүүлж архивт эх хувь баримтаар хүлээлгэн өгөх.
2. ХБИ-н налуу замын пандусын гялгар хавтан солих
3. Налуу замын эхлэл дээр самбар хийх
4. ХБИ-ий автомашины зогсоолоос явган хүний замд налуу хийх
5. ХБИ-ий ариун цэврийн өрөөнд татуурга хийх
6. Явган хүний замын голоор хөтөч хавтан хийх
7. Гадна талбайн авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээг стандартад нийцүүлэн байрлуулах.
8. Зоорийн давхарын шалыг өнгөлөх, резин будгаар будаж өгөх.
9. Шилэн фасад, металл фасадны уулзварын чигжээсийг сайтар хийх.
10. Хар цаасны ам даралтууд хөндүүрсэн байгааг засаж нааж өгөх.
11. Дээврийн парпетан бетон малгайвчийг ус чийгнээс хамгаалсан түрхлэг түрхэж өгөх.
12. Заалны ам даралтуудыг засаж янзлах.
13. Операторын өрөөнд шилэн хаалт хийж өгөх.
14. Тайзны 12х6 метр хэмжээтэй лед дэлгэцийн гүйдэг зам дагуух цахилгааны утсыг хоолойнд сүвлэж өлгөх.
15. Төв хаалганы гаднаас орж ирэх хэсэг, фестивелийн гэрэлтүүлгийн дизайн хүчин чадлыг нэмэгдүүлэх.
16. Цахилгааны самбаруудын хаягжилт, товьёо хийж өгөх, цахилгааны холболт дээр төгсгөвч шахаж холболт хийх, газардуулга гүйцээж хийх, цэвэрлэгээ хийх, ГС-17 самбарын пускатель солих
17. Ногоон байгууламжийн ажилд гурвалсан гэрээ байгуулан, хавар дулаарахаар хийж өгөх.
18. Гадна худагт байрлах шугам хоолойг дулааж ороож цэвэрлэх
19. ХХУ-ны буцах шугамд тоолуур тавих.
20. Манометр баталгаажуулах.
21. Узелийн перемичек устгах, хаягжуулах, шугамыг цэвэрлэж шаардлагатай бол нэмэлтээр ф50 тоолуур тавих.
22. Гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг хангагч байгууллагад хүлээлгэн өгөх.
23. Холбооны эхний худаг эвдэрсэн хэсгийг бүтэн болгох. худгийн таг хүзүү хийж суурилуулах.
24. Автомашины зогсоол дээрх худгийг бетон замын түвшинтэй тэгшлэх.
25. Холбооны сувагчлал барилга руу орох хэсгийг ил гаргаж кабель татахад саадгүй болгох.
26. Худгуудад тавиур хийж өгөх.
27. Ерөнхий щитний 5А-н тоолуурыг ухаалаг тоолуураар солих.
28. Тайзны хөшигний удирдлагын тавцан самбарт гэрэлтүүлэг хийх
29. Дизель генератор хэвийн ажиллагаанд оруулах, аккумлактор тавьж өгөх.
30. Хог хаягдал хадгалах цэгийг ашиглагчтай тохиролцон байгуулах.
31. Хурлын заалны цонх, зүүн жигүүрийн шатны хажуугийн босоо цонх сийгэж байгааг засах
32. Зүүн жигүүрт радиоторын бэхэлгээ хийх
33. Ариун цэврийн өрөөнд тэмдэглэгээ хийх
34. Гадна дулааны шугамын угсралтын гагнуурын ажлын акт үйлдэх
35. Ил далд ажлыг бичиж гүйцээж баталгаажуулах.
36. Худгийн таг хүзүү хийж битүүмжлэх.
37. Зогсоолын худаг сувагчлалын стандартын дагуу газрын түвшинд суурилуулах.
38. Галын щитын холболтыг шалгаж ажиллагаанд оруулах.

39. Сувагчлалын хоолойг ил гаргах.
40. Халаалтын уян хоолойн холбоосуудад хамгаалалт хийх
41. Барилгын орц гарцад нэмэлтээр халуун хөшиг хийж өгөх.
42. Утаа мэдрэгчүүдийн тагуудыг авах
43. Зургийн компанитай хамтран аваар ослын үеийн аврах зам гарцын схем зураг боловсруулж давхар бүрт байрлуулах
44. Гадна дулаалгын материалын шинжилгээний дүгнэлт
45. Барилга байгууламжинд зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах
46. Гарц заасан тэмдэг тэмдэглэгээг гарцын чиглэл зааж коридорын эргэлт бүрт байрлуулах
47. 3 давхрын паар бэхлэх, хоолойг далдлах
48. Хананы анкерыг цавуун бэхэлгээтэй боолт хийх.
49. Төв замаас авто зогсоол руу орох налуу хэсэгт ус зайлуулах суваг хийх.
50. өрөөний заримаас бохир үнэртэж байгааг янзлах
51. 2 давхарт нэг өрөөний хана ус алдаж өнгө үзэмж алдсныг засах
52. 2 давхрын паарыг бэхлэх
53. Ундны усыг шинжилгээнд хамруулж улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах.
54. Тайз, хөшиг, тоног төхөөрөмж зэрэг БНХАУ-ын гүйцэтгүүлсэн ажлын гэрээ, баталгааны дүгнэлтийг баталгаат орчуулгын газраар орчуулга хийж өгөх.

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

Аймгийн ГХБХБГ-ын дарга..................................................С.Нямжав

УЛААНБААТАР ХОТ
ДҮРТ-УУЛ
ХХК
ТТА4065 ☎ 5083974

"Дүрт Уул" ХХК-ий захирал........................................Ч.Дүгэрсүрэн

"Дүрт Уул" ХХК-ий инженер........................................Ч.Оюунчимэг

**Хурлын тэмдэглэл хөтөлсөн:**

ГХБХБГ-ын БХБХ-ийн мэргэжилтэн..............................................Б.Зоригт

"Дүрт Уул" ХХК-ий инженер........................................Л.Баясгалан